



**МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр.
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41, 32-09-16
И-мэйл: moh@moh.gov.mn, http://www.mohs.mn

2019. 07. 05 № 213149

танай _____-ны № _____-т

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ГАЗАР, НЭГДСЭН ЭМНЭЛЭГ, ГЭМТЭЛ, СОГОГ
СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ, ЭХ, ХҮҮХДИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ, ХҮҮХДИЙН
ТӨВ СУВИЛАЛ, НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВ, СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВ, БҮХ ШАТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН
БАЙГУУЛЛАГАД

“Хүүхдийн эрүүл мэнд, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, тусламж, үйлчилгээ үзүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай” Эрүүл мэндийн сайдын 2019 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 12 дугаар албан даалгаврыг батлан хавсралтаар хүргүүлж байна.

Хэрэгжилтийг хангаж ажиллана уу.

Хавсралт 4 хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА

Б.БЯМБАДОРЖ



083476



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
АЛБАН ДААЛГАВАР

2019 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот

Хүүхдийн эрүүл мэнд, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, тусламж, үйлчилгээ үзүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 4 дүгээр сарын 09-ний өдрийн 60 дугаар Зарлиг, УИХ-ын Байнгын хорооны 2018 оны 04 дүгээр тогтоол, Засгийн газрын 2019 оны 210 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий сайдын 2018 оны 07 дугаар сарын 09-ний 01 дүгээр Албан даалгавар, Хүний эрхийн үндэсний комиссын 2019 оны 06 сарын 04-ний 1/30 дугаар зөвлөмж, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоол, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2019 оны 5 дугаар сарын 18-ны хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилтийг хангах зорилгоор хүүхдийн эрүүл мэндийг сайжруулах зорилгоор тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, хүүхдийн хүчирхийлэл, осол гэмтлээс сэргийлэх дараах арга хэмжээг эрчимжүүлэхийг ДААЛГАЖ байна.

Нэг. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлгийн дарга нарт:

1.1. Хүүхдийн эрүүл мэнд, хөгжил, хамгааллын асуудлаар салбар дундын ажлын хэсэг байгуулах, батлагдсан хууль тогтоомж, шийдвэрийг бүх ажилчдад танилцуулах;

1.2. Аймаг, дүүрэгт байгуулагдаж байгаа нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байранд хүчирхийллийн хохирогч хүүхдүүдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх эмчийг томилон ажиллуулах;

1.3. Нэгдсэн эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны MNS5095:2017 стандартын дагуу өсвөр үеийн эрүүл мэндийн кабинетийг байгуулж, эмч, зөвлөгч, нийгмийн ажилтныг орон тоогоор ажиллуулах;

1.4. Хүчирхийллийн хохирогч хүүхдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээг хүлээгдэл, чирэгдэлгүй шуурхай үзүүлэх зорилгоор "Улаан карт"-аар үйлчлэх зохицуулалт хийж, хэрэгжүүлэх;

1.5. Охид, хөвгүүдийн эрхийг хүндэтгэсэн, албан ёсны зөвшөөрөл авсны үндсэн дээр үйлчилгээ үзүүлэгчдийн санаачилгаар урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо хийх, нууцлал, мэдээллийг чандлан хадгалах,

1.6. Охидын төрөлт, жирэмлэлт, үр хөндөлт болон охид эрт гэрлэж байгаа асуудлын шалтгаан, нөхцлийг судлах, бэлгийн замаар дамжих халдвар, сүрьеэг эрт илрүүлж эмчлэх, бүртгэл хяналт тандалтыг сайжруулах эмч нарын баг гарган ажиллах;

1.7. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамрагдахад тулгамдсан асуудал, орчны нөхцөл байдлын үнэлгээ хийж, тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах төлөвлөгөө гарган ажиллах

1.8. Хүүхэд ахуйн осолд өртөх орчны эрсдлийн үнэлгээ хийж, эрсдэлт хүчин зүйлсийг тодорхойлох;

1.9. Аймаг, дүүргийн гэмтэл болон яаралтай тусламжийн эмч, сувилагч, мэргэжилтэнг чадавхижуулах сургалт зохион байгуулах;

1.10. Архи, тамхи худалдаалах цэг, компьютер тоглоомын газрын байршил, нягтралын судалгаа хийж, багасгах саналыг Засаг даргын тамгын газарт хүргүүлж шийдвэрлүүлэх;

1.11. Эрүүл мэнд, боловсролын байгууллагын дотоод орчин, байгууллагын үүд, хашаа, тэдгээрийн ойр орчимд тамхи татуулахгүй байх арга хэмжээ авч, Тамхигүй байгууллага болох хөдөлгөөн өрнүүлж, олон нийтэд зарлах.

Хоёр. Бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга нарт:

2.1. Хүүхдийн эрүүл мэнд, хөгжил, хамгааллын асуудлаар ажлын хэсэг байгуулах, батлагдсан хууль тогтоомж, шийдвэрийг бүх ажилчдад танилцуулах;

2.2. Эрүүл мэндийн байгууллага бүр “Эцэг, эхийн зөвлөл” байгуулж, эцэг эхчүүдэд хүүхдийн эрүүл мэнд, сэтгэл зүй, харилцах арга барил, хүүхэд хамгааллын талаар мэдлэг олгох сургалтыг зохион байгуулах;

2.3. Эрүүл мэндийн сайдын 2018 оны “Эрүүл мэндийн үйлчилгээн дэх эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар мэдээлэх, нууцыг хадгалах тухай” 480 дугаар тушаал болон бусад холбогдох тушаал шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллах;

2.4. Хүчирхийллийн хохирогч хүүхдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээг хүлээгдэл, чирэгдэлгүй шуурхай үзүүлэх зорилгоор “Улаан карт”-аар үйлчлэх зохицуулалт хийж, хэрэгжүүлэх;

2.5. Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээг тэдний нууцлалыг хадгалсан орчинд үзүүлж, бүртгэл хяналттай болох;

2.6. Эрүүл мэндийн байгууллагын ариун цэврийн өрөөг хүүхдэд ээлтэй байлгах зорилгоор 1.1*1.6 метр зай хэмжээнд 1 суултуур, 1 нар угаагууртай байлгаж, хаалга нь гадагшаа онгойдог байлгах, эвчтөний өрөөнд ариун цэврийн өрөө төлөвлөөгүй тохиолдолд 10 эрэгтэй үйлчлүүлэгчид 1 суултуур, 1 шээлтүүр, 8 эмэгтэй үйлчлүүлэгчид 1 суултуур бүхий ариун цэврийн өрөө байлгах арга хэмжээ авах.

Гурав. Гэмтэл, согог судлалын үндэсний төвд

3.1. Нэг цэгийн үйлчилгээний төвийн санхүүжилтийн тогтвортой байдлыг хангах зорилгоор хүчирхийллийн тохиолдолд суурилсан санхүүжилттэй болох өртөг, зардлын тооцоо судалгаа хийх, санхүүжилтийн хувилбар гарган яаманд танилцуулах;

3.2. Нэг цэгийн үйлчилгээний санхүүжилтийг жил бүр байгууллагынхаа төсөвт тусгаж байх.

3.3. Осол гэмтлийн үед анхны тусламж үзүүлэх ур чадварыг эзэмшүүлэх сургалтыг цагдаа, иргэд, үйлчилгээний байгууллагын ажилтанд зохион байгуулах;

Дөрөв. Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд

4.1. Өсвөр үеийнхний эрүүл мэндийн мэдээллийн чанарыг сайжруулж, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад үзүүлж байгаа тусламж, үйлчилгээний бүртгэл, хүлээгдэл, чирэгдлийг судлан тулгамдсан асуудлыг тогтоож яаманд ирүүлэх;

4.2. Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагад үзүүлэх өсвөр үеийн эрүүл лавлагаа тусламж, үйлчилгээ болон өсвөр үеийн эрүүл мэндийн мэдээ, мэдээллийн чанарыг сайжруулах;

4.3. Өсвөр үе судлалын төрөлжсөн мэргэшлийн сургалтын хөтөлбөр боловсруулж, батлуулан 2020 онд сургалт зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах;

4.4. Бэлгийн хохирогч хүүхдийн асуудлаар Гэмтэл, согог судлалын үндэсний төв, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Хүүхдийн төв сувилалтай уулзалт зохион байгуулж, тулгамдсан асуудлыг тогтоон шийдэх.

Тав. Хүүхдийн төв сувилалд

5.1. Хүчирхийлэлд өртсөн, асаргаа сувилгаа шаардлагагай 0-3 насны хүүхдэд эрүүл мэндийн нөхөн сэргээх, сувилах, асрах үйлчилгээний чанарыг сайжруулах;

5.2. 0-3 насны хараа, хяналтгүй хүүхдэд үзүүлэх тусламж, үйлчилгээ бусад нийгмийн халамж, асаргаа явуулдаг байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулан үр дүнг тооцож ажиллах.

Зургаа. Эрүүл мэндийн хөгжлийн төвд

6.1. Эрүүл мэндийн үзүүлэлтэд өсвөр үеийнхний эрүүл мэндийн бүлэг шинээр бий болгож, мэдээллийн тогтолцоонд нэвтрүүлэх;

6.2. 2020-2021 оны сургалтын жилд Төрийн сангийн зардлаар өсвөр үеийн эмчийг төрөлжсөн мэргэшил олгох сургалт зохион байгуулах;

Долоо. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвд

7.1. Хүүхдийн дунд зонхилон тохиолдох өвчлөл, тэдгээрт нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлсээс урьдчилан сэргийлэх нэвтрүүлэг, контент гаргаж, бусад эрүүл мэндийн байгууллагуудыг хангах, олон нийтэд мэдээллийн хэрэгслээр цацах;

7.2. Орон нутагт хүүхэд ахуйн осолд өртөх орчны эрсдэлийг бууруулах, аюулгүй орчин нөхцлийг үнэлэх, эрсдэлт хүчин зүйлсийг багасгах эрсдлийн судалгаа хийхэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах;

7.3. Өсвөр насны охидод өсөлт, хөгжилт, шилжилтийн нас, үэрхэл нөхөрлөл, өөртөө итгэх итгэл, аюулгүй бэлгийн харилцаа, жирэмслэлтээс сэргийлэх, үр хөндөлт, бэлгийн хүчирхийлэл, стресс, хорт зуршлын талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сургалт, сурталчилгаа явуулах;

7.4. Интернет орчин, хэвлэл мэдээллийн хэрэгслээр явагдаж байгаа архи, тамхитай холбоотой нэвтрүүлэг, сурталчилгааны агуулга, давтамжид явц, тусгай зөвшөөрлийн асуудалд хяналт, үнэлгээ хийж, орон нутгийн Засаг даргын тамгын газар, Мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран ажиллах;

7.5. Ерөнхий боловсролын сургуулийн эмч, сэтгэл зүйчдийн мэдлэг, ур чадварыг сайжруулах сургалт зохион байгуулах.

Найм. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд:

8.1 Аймаг, нийслэлийн дүүргийн амбулаторит сэтгэл зүйч ажиллуулах асуудлыг судлах;

8.2. Хүүхэд өсвөр үеийнхний сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, сэтгэцийн тулгамдсан асуудлыг шийдэх талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр хийх мэдээлэл, сургалт, сурталчилгааны төрөл, тоог олшруулж, явуулах

8.3. Хүчирхийллийн хохирогч хүүхэд, хүчирхийлэгчид, хүнд хэлбэрийн сэтгэцийн өөрчлөлттэй, эцэг, эх асран хамгаалагч, харгалзан дэмжигчгүй хүүхэд, мансуурах болон донтох эмгэгтэй хүүхдэд үзүүлэх сэтгэл заслын хөтөлбөр, гарын авлага боловсруулж, холбогдох байгууллагуудад сургалт явуулах;

8.4. Салбарын болон бусад салбарт ажиллаж байгаа сэтгэл зүйчдэд сургалт явуулж, тогтмол мэдээллээр хангах орчин бүрдүүлэх;


8.5. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмч нарын хүүхэд өсвөр үеийнхний сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, сэтгэцийн тулгамдсан асуудлыг шийдэх зөвлөгөө өгөх ур чадварыг сайжруулах сургалт зохион байгуулах.

Ес. Бүх шатны эрүүл мэндийн байгууллагад:

9.1. Албан тушаалтны ажлын үр дүнд хяналт тавьж, сахилга, хариуцлагыг өндөржүүлж, алдаа гаргасан хариуцлага тооцож ажиллах,

9.2. Албан даалгаврыг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган хэрэгжилтийн тайланг улирал бүрээр гарган тусны яамны Нийгмийн эрүүл мэндийн газарт ирүүлэхийг Эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ